

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.06 №24 (24)

ҮЙЛ ЯВДАЛ

Д.Ганзориг: ЦЭРГИЙН АЛБАНЫ ХАРИЛЦАА ЯМАР Ч ҮЕД ДҮРМИЙН ХҮРЭЭНД ЯВАГДАХ ЁСТОЙ



Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг өчигдөр төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нартай цахим уулзалт хийлээ. Уулзалтад Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, хурандаа Ц.Жавхланбаатар, Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг болон ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нар, төрлийн цэргийн командлалын холбогдох удирдлагууд оролцлоо.

Уулзалтаар хошууч генерал Д.Ганзориг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нарт бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадвар, харилцаа, хандлага, цэргийн алба, сахилга хариуцлага, ёс зүйн хүрээнд дагнан ярилцаж, тодорхой хугацаатай үүрэг даалгавруудыг өгсөн юм.

“Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж байгуулагдсаны түүхт 100 жилийн ойгоо бид олон бүтээлч ажлыг өрнүүлж, Зэвсэгт хүчнийхээ түүхэн гавьяа, дайчин замналыг олон нийтэд алдаршуулах чиглэлээр тодорхой ажлуудыг явуулсан. Харамсалтай нь, 100 жилийнхээ дараагаар Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхээр ирсэн идэр сайхан байлдагчийг зүй бусаар алдлаа. Ийм

асуудал яагаад гарах болов. Яагаад гэхээр Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нар алба хаагчидтайгаа тулж ажиллахгүй байгаагийн жишээ. Ялангуяа, хугацаат цэргийн алба хаагчидтай ажилладаг салаа, салбарын захирагч нартайгаа ярилцахгүй, тэднийг сургахгүй, хөгжүүлэхгүй байна. Байнгын бүрэлдэхүүнтэй анги ч гэсэн ялгаагүй. Хоёрдугаарт, та бүхэн хэвшмэл болсон сургалтын тогтолцоондоо өөрчлөлт оруул. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалуудаас цэргийн алба, сахилга хариуцлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, ёс зүйн чиглэлээр хангалттай дүрэм, журам, заавар, үүрэг даалгаврыг өгч ирсэн ч энэ нь нэгтгэл, ангид очоод хадгалагдах баримт бичиг болж байгааг сүүлийн гарсан асуудлаас харж болохоор байна. Саяхан Зэвсэгт хүчний бүх алба хаагчдаасаа социологийн судалгаа авлаа. Судалгааны дүнг харахад та бидэнд ярилцмаар олон асуудал хөндөгдсөн байна. Өнөө маргаашиг төрлийн цэргийн командлал, нэгтгэл, ангиуд руу судалгааны дүнг явуулна. Та бүхэн ирэх долоо хоногийн дотор багтаж, судалгааны хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө гаргаж ЗХЖШ-т ирүүл. Дараагийн удаад Батлан хамгаалахын сайдын тушаалын

дагуу цэргийн алба хаагчдаас энэ сарын 20-ны өдрөөс эхлэн түвшин тогтоох шалгалт явуулна. Шалгалтыг офицер, ахлагч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, ёс суртахуун, сэтгэл зүйн бэлтгэл, ажил үүргийн гүйцэтгэл гээд олон талыг багтааж авна. Тааруу дүн үзүүлбэл тухайн ангийн бэлэн байдал, үүрэг гүйцэтгэлт, цэргийн алба, сахилга хариуцлага сул байна гэсэн үг. Мэдээж хариуцлага ч давхар яригдана. Мөн удахгүй Улаанбаатар цэргийн хүрээний ангиудад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлогын зөвлөх Л.Болдоор ахлуулсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хилийн цэргийн ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб, Хүний эрхийн үндэсний комиссын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсэг ажиллана. Үргэлжлүүлээд хөдөө орон нутаг дахь Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн ангиудад ажиллана. Шалгалтын нэгдсэн дүн 5 дугаар сарын 15-ны өдөр гэхэд гарна. Эдгээр шалгалтаас олон зүйл шалтгаална гэдгийг ойлгоорой. Ялангуяа, нэр бүхий зарим нэгтгэл, ангиудын захирагч нарт анхааруулж хэлэхэд 5 дугаар сарын 15-ны өдөр хүртэл сайн ажилла. Та нарт хугацаа өгье. Хэрэв алба хаагчдаа анхаарал,

хяналтаа бүрэн тавьж чадахгүй асуудал гаргавал уучлаарай, танд бид дахин итгэхэд бэрх болно. Цэргийн албаны харилцаа ямар ч үед дүрмийн хүрээнд явагдах ёстой. Найзан дундаа орчихсон, нэгэндээ шаардлага тавьж чадахгүй, бие бүрэлдэхүүнээ хөгжүүлж чадваржуулахад анхаарахгүй бол бид хөгжихгүй.

Бидэнд төсөв шаардлагагүйгээр хэрэгжүүлэх даалгавар бол манлайлал юм. Манлайлагч хүн хамгийн наад зах нь зөв шаардлага тавьж, зөв үлгэрлэл үзүүлж, зөв шийдвэр гаргаж чаддаг байх ёстой. Хэрэв алдаа гаргасан бол алдаагаа бас хүлээн зөвшөөрч чаддаг байх хэрэгтэй. Хамгийн гол нь та удирдагч хүнийхээ хувьд бие бүрэлдэхүүнээ бүрэн хянаж, хөгжүүлж, удирдан чиглүүлэх ёстой шүү” гэв. Үргэлжлүүлэн ирэх 6 дугаар сараас эхлэн олон улсын болон хамтарсан сургалт дадлагууд явагдана. Цэргийн ёслолын жагсаал 7 дугаар сарын 10-ны өдөр болно. Цэргийн зэвсэглэл, техник оролцсон ёслолын жагсаал ч мөн энэ үеэр явагдана. Бидний өмнө асар их ажил байгаа хэмээн тодотгоод бие бүрэлдэхүүнээ цар тахлаас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлуулж ажиллахад онцгой анхаарахыг захилаа.

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИДТАЙ УУЛЗЛАА

Батлан хамгаалахын сайдын тушаалаар Улаанбаатар цэргийн хүрээний хугацаат цэргийн алба хаагчидтай ангиудад томилогдсон бүрэлдэхүүн ажиллалаа. Уг ажлын хүрээнд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар Зэвсэгт хүчний анги 017, 311, 326 дугаар ангид ажилласан. Тэр бээр ангийн удирдлага, бие бүрэлдэхүүнд батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн алба, офицер, ахлагч нарын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн албан үүрэг даалгавруудыг өгсөн юм. Мөн хугацаат цэргийн алба хаагчидтай уулзаж, эх оронч үзэл хүмүүжлийн тухай ярилцаж, тэдний сэтгэгдлийг сонслоо.

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар “Сүүлийн үед Зэвсэгт хүчинд үүсээд буй нөхцөл байдалтай холбогдоод Батлан хамгаалахын сайд төрлийн цэргийн командлалууд болон Зэвсэгт хүчний ангиудад

тодорхой үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэж, тушаал гаргасан. Энэ хүрээнд үндсэн хэд хэдэн ажил хийхээр тусгагдсан. Зэвсэгт хүчинд алба хааж байгаа офицер, ахлагч нарын ёс зүй, ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадварт дүнгэлт хийхээр түвшин тогтоох шалгалтыг энэ ондоо багтааж явуулахаар төлөвлөвөө. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бүх ангиудын камержуулалтыг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах талд тодорхой ажлууд тусгагдсан. Эхнээсээ ажил болоод явж байна. Хугацаат цэргүүдтэй ажилладаг салаа, салбарын захирагч нартай уулзаж, тэдний санал сэтгэгдлийг сонслоо. Хугацаат цэргүүдтэй ч уулзлаа. Ер нь бид бодит мэдээлэлд тулгуурлан нийгмийн хөгжилтэйгээ уялдуулж ажиллах хандлагаа өөрчлөх цаг нь болжээ” гэв.

Байлдагч М.Өсөхбаяр “Би Дархан-Уул аймагт төрсөн. Одоо СЭЗИС-д бизнесийн удирдлагын гуравдугаар курсэд суралцаж байна.



Цар тахлын улмаас цахимаар хичээллэж байгаа нь надад үр дүнгүй мэт санагдсан учир энэ үеийг ашиглаад цэргийн алба хаахаар шийдсэн юм. Илүүдэл жингээсээ салсан. Эрүүл мэнд, бие бялдар сайжирч, олон найз нөхөдтэй ч болж байна. Би чөлөөт цагаараа англи

хэл судалдаг. Энд ирээд цэргийн англи хэлний “ALCPT” шалгалтыг 98 оноотой өгсөн. Онжавууддаа чөлөөт цагаараа англи хэлний мэдлэгээсээ хуваалцдаг. Цэргийн албанд ирээд энэ мэт олон талаараа өөрийгөө хөгжүүлж, чадваржуулж байна” хэмээн хэллээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
+10	-5

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
+34	+24

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
+14	+4

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.849.00	2.852.00
EUR	3.355.0	3.365.0
CNY	433.00	434.20
RUB	36.80	38.30
JPY	25.47	25.96
KRW	2.44	2.57

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 25
2021.04.06.
/МЯГМАР ГАРАГ/

**ХАВРЫН ДУНД
ЦАГААЧИН ТУУЛАЙ
САРЫН ХОЁР ХАР ХӨХ
БИЧ ӨДӨР**

Үс засуулбал:
Нүд бүрэлзэн улайна
Наран ургах, шингэх:
06.20-19.29

Барилдлага:
Түлэх
Шүтэн барилдлага:
Сэрэхүй

Суудал:
Гал.

Аргын тооллын 4 дүгээр сарын 6, Ангараг гараг. Билгийн тооллын 25, Булаач одтой од, хөх бич өдөр. Өдрийн наран 6 цаг 20 минутад мандан, 19 цаг 29 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөрт гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, хараал, жатхыг буцаах, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн.

Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжтой.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН

602

НИЙТ БҮРТГЭГДСЭН

10281

ЭДГЭРСЭН

5646

НАС БАРСАН

16

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНӨЛӨГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН

10

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ

253

ЭДГЭРСЭН

1244

НИЙТ БАТЛАГДСАН


1502

МУ-ын хэмжээнд 04 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар нийт 414382 (22.4%) иргэн Ковид-19 эсрэг вакцины эхний тунд хамрагдлаа.

Нийслэлд нийт 372876 иргэн Орон нутагт нийт 41506 иргэн

ҮЙЛ ЯВДАЛ

Б.Гантөмөр: ЦЭРГИЙН НИЙТЛЭГ ДҮРЭМ БОЛ БИДНИЙ ҮНДСЭН ХУУЛЬ ЮМ



Зэвсэгт хүчний Жанжин штабын ахлагч, тэргүүн ахлагч Б.Гантөмөр өчигдөр Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын тэргүүн ахлагч, салаа, салбарын даргалах ахлагч нартай цахимаар хуралдлаа.

Тэрээр Зэвсэгт хүчний 326 дугаар ангид гарсан асуудалтай холбогдуулан нэгтгэл, ангиудын ахлагч нар Цэргийн нийтлэг дүрмийг ягштал биелүүлэхэд онцгой

анхаарахыг үүрэг болгож. Цэргийн нийтлэг дүрэм бол бидний Үндсэн хууль юм бөгөөд бүх харилцаа дүрмийн хүрээнд явагдах ёстойг ЗХЖШ-ын дарга хатуу анхааруулсныг уламжлав. Үргэлжлүүлэн аливаа зөрчил, дутагдлыг гарсны дараа биш гарахаас өмнө урьдчилан сэргийлж, ахлагчийн бүрэлдэхүүнийхээ сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэхэд тухайн нэгтгэл, ангиудын даргалах

албан тушаалын ахлагч нар идэвх санаачилгатай ажиллах сануулж, цэргийн ёсоор захирахаас гадна хүний ёсоор хайрладаг сайхан уламжлал монгол цэргийн түүхэнд байдгийг ч иш татан онцолж, 2021 онд ахлагчийн бүрэлдэхүүний эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлтийг дээшлүүлэх зорилгыг хэрэгжүүлэхэд ахлагч бүрийн оролцоо чухал гэдгийг хэлсэн юм.

ЦАХИМ ШУУДАНД

"ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТЫН ДУРСГАЛЫН МЕДАЛЬ"-ААР МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙГ ШАГНАВ

Дэлхийн II дайны ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан 1941-1945 оны Аугаа их эх орны дайнд оролцсон ахмад дайчдын нийгэм-эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх, хүүхэд залуус, иргэдэд эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлэн Монгол Улсын БХЯ-ны харьяа Монгол цэргийн музейг "Эх орны дайны ялалтын дурсгалын медаль"-иар шагнасан бөгөөд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинээс ирүүлсэн "БАТЛАМЖ"-ийг Монгол цэргийн музейн захирал, хурандаа Д.Ганзоригт Оросын шинжлэх ухаан соёлын төвийн захирал, Оросын хамтын ажиллагаа байгууллагын захирал, Монгол Улс дахь Орос Улсын Элчин сайдын зөвлөх А.Р.Базархандаев гардууллаа.



Музею Монгольского воина
Министерства обороны Монголии

вручена памятная медаль «75 лет Победы в Великой Отечественной войне 1941-1945 годов» за активное участие в патриотическом воспитании граждан и решении социально-экономических проблем ветеранов Великой Отечественной войны 1941-1945 гг.

В. Путин

НАЙМАН ХҮНД ХҮНСНИЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 336 дугаар анги Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах санаамж бичиг байгуулав. Уг ажлын хүрээнд цар тахал тархаж байгаа хүндхэн цаг үед

тусоамж болгож тус ангийн олон хүүхэдтэй, өрх толгойлсон, өрхийн орлого доогуур 8 ажилтан алба хаагчдад хүнсний нэг удаагийн багцыг өглөө.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ

ХАРИЛЦААНААС ХАРИЛЦАА ҮҮСНЭ



Зэвсэгт хүчний 123 дугаар анги

Цар тахлын халдварын тархалтаас үүдэн Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран цэргийн алба хаагчдыг ар гэрийнхэнтэй нь утас болон интернетээр холбох ажлыг зохион байгуулж байна. Мөн баяр, амралтын өдрүүдэд төлөвлөгөөний дагуу албан даалгаварыг танилцуулж, дэлхий дахинд болон Монгол оронд болж буй мэдээ мэдээллийг хүргэн, цэргийн албаны талаар үүрэг чиглэл өгч байна. Мөн "Харилцаанаас харилцаа үүснэ", "Нэг хором тэвч, нэгнийгээ хүндэтгэе", "Би хүндэтгэж байна, харин та" гэсэн уриалгыг дэвшүүлж алба хаагч бүр мөрдлөг болгон ажиллаж байна.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ

ТАНЫ СОНОРТ

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫГ ТОГТМОЛЖУУЛЖ, ТАЙПАН МЭДЭЭГ БАТЛАГДСАН ЦАГЛАБАРЫН ДАГУУ ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА



Хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэх бодлого зорилтын хүрээнд 2021 оны босгон дээр Батлан хамгаалахын сайдын тушаалаар дотоод, хяналт шалгалттай холбоотой дүрэм, журмууд шинэчлэгдэж, салбарын хэмжээнд хяналт шалгалтыг нэгдсэн бодлого, төлөвлөлт, уялдаа холбоотойгоор тогтмол зохион байгуулах эрх зүйн орчин бүрдсэн.

Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/294, А/295 дугаар тушаалуудаар, батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналт, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг зохион байгуулах тухай нийтлэг журмуудыг баталж, үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг хангахыг харьяа бүх шатны төсвийн захирагч, төрийн өмчит байгууллагын дарга нарт даалгасан бөгөөд хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчид хариуцуулсан билээ.


2021 оны 1 дүгээр сард яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар шинээр батлагдсан дүрэм, журмууд болон хяналт шалгалттай холбоотой бусад хууль, эрх зүйн баримт бичгүүдийг нэгтгэсэн гарын авлага гаргаж, сайдын эрхлэх асуудлын хүрээний нийт 80 гаруй байгууллага, 330 алба хаагчдыг хамруулсан "Дотоод хяналт шалгалтыг

зохион байгуулах, үр дүнг дээшлүүлэх нь" сэдэвт цахим сургалтыг зохион байгуулан, эрх зүйн баримт бичгүүдийг сурталчлан таниулах, дотоод хяналт шалгалтыг анги, байгууллагад хэрхэн үр дүнтэй зохион байгуулах талаар мэргэжлийн зөвлөмж, аргачлалаар хангасан. Цаашид Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын хэрэгжилтийг салбарын хэмжээнд хангуулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, батлагдсан цаглабарын дагуу дотоод хяналт, шалгалтын улирлын тайлангуудыг хүлээн авч, жилийн эцсийн дүнг Батлан хамгаалахын дотоод аудитын хороонд танилцуулж, шийдвэрлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, анги, байгууллагуудын дарга /захирагч/ нар болон, дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй албан тушаалтнууд байгууллагын дотоод хяналтыг тогтмолжуулж, үр дүнтэй зохион байгуулснаар учирч болох аливаа эрсдэл, гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулж, таслан зогсоход өндөр ач холбогдолтой юм.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

1800-1144 УТСАНД ХАНДАЖ САНАЛ ГОМДЛОО ӨГӨӨРЭЙ



Иргэн та БХЯ-наас ажиллуулж байгаа 1800-1144 гэсэн дугаарт холбогдох иргэний хяналтаа хийхээс гадна санал гомдлоо чөлөөтэй илэрхийлэх боломж бүрдлээ. Тус утас нь 24 цаг тасралтгүй ажиллах бөгөөд иргэдээс ирсэн бүхий л төрлийн санал гомдлыг хүлээн авч холбогдох албан тушаалтнуудаас хариу авч эргэж мэдээлэлж байх юм. Мөн батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээлэлээр таныг ханган ажиллах юм.

ЭНЭ САРД ХИЙГДЭХ ТУСГАЙ ҮҮРГИЙН НИСЛЭГИЙН ХУВААРЬ

Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу энэ сард нийт 12 удаагийн тусгай үүргийн нислэг үйлдэж, 2,000 орчим иргэнээ татан авахаар төлөвлөжээ.

Тусгай үүргийн нислэг	Тусгай үүргийн нислэг	Тусгай үүргийн нислэг
1. СӨҮЛ СОЛОНГОС	- 04.01	/160/
2. ТОКИО	- 04.06	/160/
3. СӨҮЛ СОЛОНГОС	- 04.07	/160/
4. ИСТАНБУЛ	- 04.10	/250/
5. ТОКИО	- 04.13	/160/
6. СӨҮЛ АСИАНА ЭЙРЛАЙНС	- 04.14	/160/
7. ФРАНКФУРТ	- 04.15	/160/
8. СӨҮЛ СОЛОНГОС	- 04.21	/160/
9. СӨҮЛ ТРАНЗИТ	- 04.23	/160/
10. СӨҮЛ СОЛОНГОС	- 04.27	/160/
11. СӨҮЛ КОРЕАН ЭЙР	- 04.28	/160/
12. ФРАНКФУРТ	- 04.29	/160/

ЗОРЧИГЧ: 2100 орчим